

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ
НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2010.05.11

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2010 оны нэгдүгээр улиралд 10 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 3 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 184 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

2010 оны нэгдүгээр улирлын байдлаарх ББСБ-уудын тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

/Хүснэгт 1/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант улирлаар	Өмнөх оны мөн үеэр
1	ББСБ-ын тоо	184	132
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	582	442
3	Ажиллагсадын тоо	850	603
4	Салбар нэгжийн тоо	64	46
5	Харилцагчдын тоо	46,456	40,250
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	106,943,599.6	79,142,638.6
	Банкны салбарт эзлэх хувь	2.4	2.0
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	62,421,241.1	46,029,757.4
	Банкны салбарт эзлэх хувь	2.9	1.7
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	79,217,698.0	59,294,746.6
	Банкны салбарт эзлэх хувь	31.9	17.2
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	71,961,587.7	50,953,035.0
	Банкны салбарт эзлэх хувь	26.3	20.3
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	5,395,174.6	3,404,143.1
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	6,326,944.4	8,356,435.2
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	5,358,007.0	6,826,386.0
13	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	968,937.4	1,530,049.2
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	10	11
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	4.9	8.3
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	16,985,289.2	15,471,456.7
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	15.9	19.5
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	12,041,935.4	9,394,216.65
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	19.3	20.4
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,371,456.2	9,982,584.90
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	9.3	16.8
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	7,821,032.5	10,577,790.25
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	10.9	20.8
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	28	23
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	15.2	17.4
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	3,028,003.2	2,016,875.55
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.8	2.5

Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	3,228,456.9	1,641,054.79
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	5.2	3.6
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	2,779,771.9	1,696,113.79
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	3.5	2.9
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	2,767,567.1	1,459,320.94
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	3.8	2.9
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	51	1
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	27.7	0.8
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	7,118,112.3	481,113.9
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	6.7	0.6
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,098,968.2	479,780.0
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	9.0	0.8
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	6,435,661.2	400,000.0
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	8.9	0.8

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 10 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 4.9 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.9 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 19.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 9.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 10.9 хувийг тус тус эзэлж байна. Тэдгээрийг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 5, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 1, Итали улсын хөрөнгө оруулалттай 1, АНУ-ын хөрөнгө оруулалттай 1, ОХУ-ын хөрөнгө оруулалттай 1 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар орон нутагт 28 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 15.2 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 2.8 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 5.2 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.5 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.8 хувийг тус тус эзэлж байна.



Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаад валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 47 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 5 ББСБ буюу нийт 51 ББСБ зөвхөн гадаад арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 27.7 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 6.7 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 9.0 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 8.9 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 2/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо	
		Тайлант улирлаар	Өмнөх оны мөн үеэр
1	Зээл	137	130
2	Факторингийн үйлчилгээ	6	7
3	Төлбөрийн баталгаа гаргах	5	3
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	7
6	Гадаад валютын арилжаа	112	51
7	Итгэлцлийн үйлчилгээ	9	13
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	3
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	7	8
10	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ	1	0

ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн болон татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин:

/Хүснэгт 3/

№	Үзүүлэлт	Хүүгийн хувь	
		Тайлант улирлаар	Өмнөх оны мөн үеэр
1	Дээд хүү /зээл, активын/	4.8	4.5
	Доод хүү /зээл, активын/	2.5	3.0
2	Дээд хүү /бусдаас татсан эх үүсвэрийн/	0.4	2.0
	Доод хүү /бусдаас татсан эх үүсвэрийн/	0.2	0.5

2010 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 13 ББСБ буюу нийт ББСБ-ын 7.1 эхлэлтийн санхүүгийн тайлангаар, мөн 13 ББСБ өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр тус тус хамрагдлаа.

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**2.1 Активын бүтэц, өөрчлөлт:**

ББСБ-уудын 2010 оны 1 дүгээр улирлын байдлаарх нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/

№	ХӨРӨНГӨ	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	102,538,526.2	95.9	75,249,362.2	95.1	27,289,164.0	26.6
1	Мөнгөн хөрөнгө	34,395,691.5	32.2	25,066,777.9	31.7	9,328,913.6	27.1
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	2,004,492.4	1.9	29,944.1	0.0	1,974,548.3	98.5
	(Хөрөнгө оруулалтын үнэт цаасны эрсдлийн сан)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3	Нийт зээл	62,421,241.1	58.4	46,029,757.4	58.2	16,391,483.8	26.3
	(Зээлийн эрсдлийн сан)	58,884,487.4	55.1	2,886,946.6	3.6	55,997,540.7	95.1
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,080,001.9	1.0	779.5	0.0	1,079,222.4	99.9
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0	779.5	0.0	-779.5	-100.0
5	Нийт факторингийн тооцооны авлага	417,101.6	0.4	350.0	0.0	416,751.6	99.9
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	350.0	0.0	350.0	0.0	0.0	0.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	389,429.1	0.4	86,015.9	0.1	303,413.2	77.9
	(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдлийн сан)	54,416.4	0.1	17,231.7	0.0	37,184.7	68.3
7	Бусад хөрөнгө	5,367,672.4	5.0	6,923,813.6	8.7	-1,556,141.2	-29.0
Б	Эргэлтийн бус хөрөнгө	4,405,073.4	4.1	3,893,276.4	4.9	511,797.0	11.6
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,405,073.4	4.1	3,893,276.4	4.9	511,797.0	11.6
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	5,866,934.8	5.5	4,994,157.0	6.3	872,777.8	14.9
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,461,861.4	1.4	1,100,880.6	1.4	360,980.8	24.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		106,943,599.6	100.0	79,142,638.6	100.0	27,800,961.0	26.0

2010 оны 1 дүгээр улиралд нийт актив өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар өссөн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 25.1 хувь /үүнээс: хоёрдогч өглөг 53.8 хувь/, итгэлцлийн үйлчилгээний өглөг 36.9 хувь, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 39.4 хувиар тус тус өссөнтэй шууд холбоотой.

Мөн тайлант хугацаан дахь зээлийн үлдэгдэл нь нийт активын 58.4 хувь, мөнгөн хөрөнгө 32.2 хувийг буюу нийт 90.6 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй

үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байж, бусад санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээг төдийлэн эрхлэхгүй байгаатай холбоотой.

2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 5/

№	Ангилал	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
		Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь	Дүн /мян. төг/	Хувь
1	Хэвийн зээл	54,764,824.7	87.7	39,171,681.0	85.1	15,593,143.7	28.5
2	Хугацаа хэтэрсэн зээл	2,484,781.0	4.0	2,120,125.5	4.6	364,655.6	14.7
3	Чанаргүй зээл:	5,171,635.4	8.3	4,737,950.9	10.3	433,684.5	8.4
	а/ Хэвийн бус	1,386,688.3	2.2	1,876,040.2	4.1	-489,351.8	-35.3
	б/ Эргэлзээтэй	1,336,720.2	2.1	1,010,810.5	2.2	325,909.7	24.4
	в/ Муу	2,448,226.9	3.9	1,851,100.3	4.0	597,126.6	24.4
Нийт		62,421,241.1	100.0	46,029,757.4	100.0	16,391,483.8	26.3

Зээлийн багцын хэмжээ өссөн нь ББСБ-уудын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өссөнтэй холбоотойгоор 2010 оны 1 дүгээр улирлын тайлант хугацаанд нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 16,391,483.8 мянган төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн байна.

Харин зээлийн багцын бүтцийн хувьд нийт зээлийн багцад эзлэх хэвийн зээл 2.6 хувиар өссөн, хугацаа хэтэрсэн зээл 0.6 хувиар, чанаргүй зээл 2.0 хувиар тус тус буурсан байна.

ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2010 оны 1 дүгээр улирлын байдлаарх нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	24,903,580.0	23.3	17,316,274.5	21.9	7,587,305.4	30.5
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	5,395,174.6	5.0	3,404,143.1	4.3	1,991,031.6	36.9
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	14,449,819.6	13.5	8,763,502.0	11.1	5,686,317.6	39.4
3	Бусад эх үүсвэр	1,213,845.3	1.1	2,563,686.1	3.2	-1,349,840.8	-111.2
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	1,059.3	0.0	0.0	0.0	1,059.2	100.0
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1,208,885.4	1.1	2,264,104.4	2.9	-1,055,219.0	-87.3
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	0.0	0.0	2,388.0	0.0	-2,388.0	0.0
	Факторингийн үйлчилгээний өглөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,900.6	0.0	297,193.7	0.4	-293,293.1	-7519.2
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,844,740.4	3.6	2,584,943.4	3.3	1,259,797.0	32.8
	Бусад өр төлбөр	2,822,321.6	2.6	2,531,617.5	3.2	290,704.1	10.3
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	369,682.9	0.3	258,507.1	0.3	111,175.8	30.1
7	Бусад пассив	2,452,638.8	2.3	2,273,110.4	2.9	179,528.4	7.3
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Нийт өр төлбөр	27,725,901.6	25.9	19,847,892.0	25.1	7,878,009.6	28.4
Б	Эзэмшигчдийн өмч	79,217,698.0	74.1	59,294,746.6	74.9	19,922,951.4	25.1
9	Хувьцаат капитал	71,961,587.7	67.3	50,953,035.0	64.4	21,008,552.7	29.2
10	Бусад өмч	547,221.8	0.5	546,077.5	0.7	1,144.4	0.2
11	Сангууд	1,123,616.8	1.1	1,167,397.0	1.5	-43,780.1	-3.9
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	4,723,557.8	4.4	6,230,103.3	7.9	-1,506,545.5	-31.9
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	861,713.9	0.8	398,133.9	0.5	463,580.0	53.8
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	106,943,599.6	100.0	79,142,638.6	100.0	27,800,961.0	26.0

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 28.4 хувиар, эзэмшигчдийн өмч 25.1 хувиар өссөн бөгөөд 2009 оны 1 дүгээр улирлын тайлант хугацаанд нийт пассивын 25.1 хувийг нийт өр төлбөр, 74.9 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2010 оны 1 дүгээр улирлын байдлаарх нийт пассивт эзлэх нийт өр төлбөр 25.9 хувь, эзэмшигчийн өмч 74.1 хувьтай байна.

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 9 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн итгэлцлийн үйлчилгээний өглөг 5,395,174.6 мянган төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 36.9 хувиар өссөн бол мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн нийт мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн дүн 1,208,885.4 мянган төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 87.3 хувиар буурсан байна. Мөн хоёрдогч өглөгийн хэмжээ 53.8 хувиар өссөн байна.

ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 25.1 хувь /үүнээс: хоёрдогч өглөг 53.8 хувь, дүрмийн сан 29.2 хувь/, итгэлцлийн үйлчилгээний өглөг 36.9 хувь, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 39.4 хувиар өсчээ.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн бүтцийн хувьд нийт пассивт эзлэх хувь хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт өр төлбөр 0.8 хувиар өссөн, нөгөөтэйгүүр нийт эзэмшигчдийн өмч 0.8 хувиар буурсан байна.

2010 оны 1 дүгээр улирлын эцэст 1 ББСБ-ын тайлангаар 1,059.3 мянган төгрөгийн зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр бүртгэлтэй байгаа бол хоёрдогч өглөгтэй 7 ББСБ байна.

ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2010 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар буурсан ба дараах бүтэцтэй байна.

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	4,470,837.9	70.7	3,507,697.5	42.0	963,140.4	27.5
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	4,240,198.8	67.0	3,422,051.2	41.0	818,147.6	23.9
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	151,342.3	2.4	73,919.2	0.9	77,423.1	104.7
	Үнэт цаасны хүүгийн орлого	12,121.4	0.2	0.0	0.0	12,121.4	#DIV/0!
	Бусад хүүгийн орлого	67,175.4	1.1	11,727.2	0.1	55,448.3	472.8
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	1,725,481.6	27.3	4,738,684.3	56.7	-3,013,202.6	-63.6
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	122,656.9	1.9	109,794.6	1.3	12,862.3	11.7
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	7,968.0	0.1	258.8	0.0	7,709.2	2978.4
	НИЙТ ОРЛОГО	6,326,944.4	100.0	8,356,435.2	100.0	-2,029,490.8	-24.3

2010 оны тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар буурсан нь ББСБ-уудын хүүгийн зардал 43.5 хувь, хүүгийн бус орлого 63.6 хувиар буурсантай шууд холбоотой.

Өмнөх оны мөн үеийн тайлангаарх хүүгийн бус орлогын 35.7 хувь буюу 1,691,271.3 мянган төгрөгийг арилжааны орлого, 59.2 хувь буюу 2,806,748.8 мянган төгрөгийг ханшийн болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 5.1 хувь буюу 240,664.2 мянган төгрөгийг санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2010 оны 1 дүгээр улирлын байдлаар 33.6 хувь буюу 580,560.4 мянган төгрөгийг арилжааны орлого, 44.6 хувь буюу 769,644.0 мянган төгрөгийг ханшийн болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 21.7 хувь буюу 375,277 мянган төгрөгийг санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Тайлант хугацааны нийт орлогын 70.7 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 28.7 хувиар өссөн/, 27.3 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 29.4 хувиар буурсан/ эзэлж байна.

Тайлант хугацаанууд нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.03.31		2009.03.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	541,591.1	10.1	377,525.4	5.5	164,065.7	43.5
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	3,893,429.8	72.7	5,030,833.1	73.7	-1,137,403.3	-22.6
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	689,198.2	12.9	1,200,783.0	17.6	-511,584.8	-42.6
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	38,633.2	0.7	35,577.7	0.5	3,055.5	8.6
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	24,781.7	0.5	5,658.0	0.1	19,123.7	338.0
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	170,373.0	3.2	176,008.7	2.6	-5,635.8	-3.2
	НИЙТ ЗАРДАЛ	5,358,007.0	100.0	6,826,386.0	100.0	-1,468,379.0	-21.5

2010 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны нийт зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувь буурсан нь хүүгийн бус зардал, болзошгүй эрсдэлийн зардал, орлогын татварын зардлуудын бууралттай шууд холбоотой. Харин бүтцийн хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

ББСБ-ууд нь 2010 оны 1 дүгээр улирлын тайлант хугацаанд нийт 968,937.4 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36.7 хувийн бууралттай /2009 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны цэвэр ашиг 1,530,049.2 мянган төгрөг/ буюу тайлант үеүдийн нийт орлоготой харьцуулахад 3.0 хувиар буурсан /2009 онд 18.3 хувь, 2010 онд 15.3 хувь/ үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, өмнөх онтой харьцуулахад системийн хувьд үйл ажиллагааны үр ашиг буурсан байна.

ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түюшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 79,217,698.00 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 71,197,739.31 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 109.6 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 111.3 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 72.9 хувь;

- түргэн борлогдох актив 36,930,543.5 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 18,618,801.3 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 198.3 хувь;

- гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, кассет байгаа бэлэн валют, банкин дахь валютын харилцах дансан дахь үлдэгдэл нийт 19,689,058.1 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 9,836,725.1 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдлийн зохистой харьцаа 12.4 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 5,395,174.6 мянган төгрөг, хувьцаат капитал 71,961,587.7 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 7.5 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 1,914,894.14 мянган төгрөг, нийт актив 106,943,599.6 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.8 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 125/50 дугаар хамтарсан тушаалаар баталсан өөрчлөлтийн дагуу активын эрсдэлийн санг 3,752,583.8 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 8,289.2 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 3,345,452.80 мянган төгрөгөөр байгуулсан байна.

ЗУРГАА. БУСАД

2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 177 ББСБ хамрагдсанаас 2010 оны 1 дүгээр улиралд 107 ББСБ буюу нийт ББСБ-ын 60.5 хувь нь 2009 оны жилийн аудитласан санхүүгийн тайланг Хороонд ирүүлсэн.

Хорооны 2008 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-ын дагуу ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын дүнгээр санхүүгийн тайлан тэнцэлд үндэслэн холбогдох үзүүлэлтүүдийг тооцож бодитой үнэлгээ, дүгнэлт өгөхтэй холбогдуулан

нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай, 200,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 200,000.0 мянган төгрөг хүртэл активтай болон зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ гэсэн 4 бүлэгт хуваалаа.

ББСБ бүрийн активын өөрчлөлтөөс хамаарч эдгээр бүлгүүдийн бүтэц нь улирал тутамд шинэчлэгдэж байх ба 2010 оны 1 дүгээр улирлын байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

1. “Бүлэг 1” дэх 1,047,650.8 мянган төгрөгөөс 8,223,778.4 мянган төгрөг хүртэлх хэмжээний активтай нэр бүхий 23 ББСБ-ын 60,067,756.8 мянган төгрөгийн актив нь системийн нийт активын 56.2 хувийг;
2. “Бүлэг 2” дахь 205,941.4 мянган төгрөгөөс 906,735.7 мянган төгрөг хүртэлх хэмжээний активтай нэр бүхий 88 ББСБ-ын 37,736,184.3 мянган төгрөгийн актив нь системийн нийт активын 35.3 хувийг;
3. “Бүлэг 3” дахь 22,011.7 мянган төгрөгөөс 199,249.7 мянган төгрөг хүртэлх хэмжээний активтай нэр бүхий 22 ББСБ-ын 2,021,546.4 мянган төгрөгийн актив нь системийн нийт активын 1.9 хувийг;
4. “Бүлэг 4” дэх 46,506.8 мянган төгрөгөөс 999,599.0 мянган төгрөг хүртэлх хэмжээний активтай зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй нэр бүхий 51 ББСБ-ын 7,118,112.3 мянган төгрөгийн актив нь системийн нийт активын 6.7 хувийг тус тус эзэлж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР